



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.09 № 03/52 ЧАТ/САТ/2014/ЗТНМТ

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын дагуу БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газарт 2012 оноос эхлэн хэрэгжиж буй “Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн хүрээнд 45,649.6 мянган ам.долларыг дамжуулан зээлдүүлэх тесөл хүчин төгөлдөр болжээ.  
2012 онд төслийн санхүүжилтэд 9,276,784,647.32 төгрөг, 2013 онд 3,769,464,052.45 төгрөг нийт 13,046,248,699.78 төгрөг олгож дамжуулан зээлийн авлагаар бүртгэсэн боловч одоо болтол зээлийн гэрээ байгуулаагүй, Мэдээлэл харилцаа холбооны сүлжээ ТӨК-ийн харилцагчын нэр дээр зээлийн авлага бүртгэгдсэн боловч тус байгууллагын тайлан тэнцэлд бүртгэлгүй, төслийг хэрэгжүүлэгч Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газарт ч бүртгэлгүй байна.
- 2012 оны санхүүгийн аудитаар албан шаардлага өгч Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газартай гэрээг яаралтай байгуулж, 2012 онд төслийн санхүүжилтэд олгосон 9,276,784,647.32 төгрөгийг тус газрын санхүүгийн тайланд тусгуулах, гэрээг байгуулах хүртэл хугацаанд төслийн санхүүжилтийг зогсоох арга хэмжээ авч ажиллахыг шаардсан боловч биелүүлэлгүй тайлант онд 1,978,472,359.44 төгрөгийг нэмж олгосон ба валютын ханшийн зөрүүгээр 1,790,001,693.02 төгрөг нэмэгдэж жилийн эцсийн үлдэгдэл 13,046,248,699.78 төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.7, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 3.2, 3.3, 3.4 дүгээр заалтуудыг зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Дээр дурдсан төслийн санхүүжилтийн гэрээг Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газартай байгуулж, төслийн санхүүжилтэд олгосон 13,046,248,699.78 төгрөгийг тус газрын санхүүгийн тайланд тусгуулах, гэрээг байгуулах хүртэл хугацаанд төслийн санхүүжилтийг зогсоох арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, ерийн удирдлагын газрын дарга Б.Нямаа нарт даалгав.

АУДИТОР

УХААЛГАА

Б.Сэргэмждаг

Akt, alban shaardлага-A4 бланк